

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭДИЙН ЗАСГИЙН СУРГУУЛЬ

САНХҮҮГИЙН ТЭНХИМ

ЦЭГМЭДИЙН ӨНӨРЗАЯА

Хувьцаат компаний санхүүгийн шинжилгээний үр дүн

Мэргэжлийн индекс: E340400

Бизнесийн удирдлагын магистрын
зэрэг горилсон магистрын ажил

Магистрын ажлын удирдагч:
Доктор А.Ганзориг

Шүүмжлэгч:
Доктор В.Данаасүрэн

УЛААНБААТАР ХОТ.

2013 он.

Хамгаалуулах зөвлөлийн:

Дарга:..... Д.Дуламсүрэн Ph.D

Орлогч дарга:

Нарийн бичгийн дарга:..... В.Данаасүрэн Ph.D

Эрдэм шинжилгээний удирдагч:.....

Доктор А.Ганзориг

Хамгаалсан 2013 оны 5-р сар 30-ны өдөр

АГУУЛГА

Хураангуй	iv
ОРШИЛ.....	1
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХУВЬЦААТ КОМПАНИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	3
1.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГАЗҮЙ	3
1.2 САНХҮҮГИЙН ХАРЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ.....	8
1.3 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГАЧИЛАЛ.....	16
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУВЬЦААТ КОМПАНИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....	22
2.1 ХУВЬЦААТ КОМПАНИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХАРЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....	23
2.2 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....	38
ДҮГНЭЛТ.....	42
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	44
ХАВСРАЛТ	45

Товч хураангуй

Энэхүү магистрын дипломын ажлаар МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниудын 2010, 2011, 2012 оны жилийн эцсийн тайлан мэдээнд үндэслэн тэдгээр компаниудын санхүүгийн харьцааны шинжилгээгээр салбарын дундаж үзүүлэлтийг он тус бүрээр тооцох зорилготойгоор судалгаа хийсэн.

МХБ-д бүртгэлтэй 329 хувьцаат компани байгаагаас 100 хувь төрийн өмчийн 23 хувьцаат компани, төрийн өмчийн оролцоотой 29 хувьцаат компани, хувийн өмчийн 277 хувьцаат компани байна. Эдгээрээс МХБ-ийн вэбсайтад санхүүгийн тайлан нь нийтлэгдсэн хувьцаат компаниудын 2010, 2011, 2012 оны санхүүгийн тайланд шинжилгээ хийж гүйцэтгэлээ. Хувьцаат компаниудын баланс, орлого үр дүнгийн тайланг нэг хэлбэрт оруулан нэгтгэж санхүүгийн харьцааны болон эрсдэлийн шинжилгээг хийсэн болно. МХБ-ийн вэбсайтад нийтлэгдсэн хувьцаат компаниудын хураангуй болон дэлгэрэнгүй тайланг ашигласан бөгөөд зарим компаниудын тайлангийн алдаатай, дутуу байдал нь тайлангуудыг нэгтгэх явцыг хүндрүүлж байлаа. Түүнчлэн дээрх шалтгааны улмаас баланс, орлого үр дүнгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн 2010 оны 78 хувьцаат компани, 2011 оны 202 хувьцаат компани, 2012 оны 200 хувьцаат компанийг судалгаанд хамруулсан. Судалгаанд хамрагдсан хувьцаат компаниудыг МХБ-ын ангилснаар Уул уурхай, Аж үйлдвэр, Хөдөө аж ахуй, Барилга тээвэр, Худалдаа үйлчилгээ гэсэн 5 салбарт хувааж, санхүүгийн харьцааны дундаж үзүүлэлтүүдийг тооцож гаргасан.

Тооцооллын үр дүнд хөрвөх чадварын шинжилгээний үзүүлэлтүүд аль ч салбарын хувьд өндөр байна. Бараа материалын эргэц барилгын салбарын хувьд хамгийн их буюу бараа материалын дундаж наслалт хамгийн бага байгаа нь энэ салбарын үйл ажиллагаа бусад салбараас илүү идэвхитэй байгааг илэрхийлж байна. Харин авлага цуглуулах дундаж хугацаа хамгийн бага байгаа салбар нь худалдаа үйлчилгээний салбар байна. Тиймээс барилга тээвэр ба худалдаа үйлчилгээний салбарын үйл ажиллагааны эргэлтийн хугацаа ойролцоо бөгөөд бага байна.

Ашигт ажиллагааны харьцааны дундаж нь эерэг гарсан салбар байхгүй байгаа нь манай хувьцаат компаниудын ихэнх нь алдагдалтай ажиллаж буйг илэрхийлж байна.

ОРШИЛ

Зорилго, зорилтууд: МХБ-д бүртгэлтэй, үнэт цаас нь арилжаалагдаж буй хувьцаат компаниудын санхүүгийн тайланд шинжилгээ хийж үр дүнг нэгтгэн, дүгнэхэд дипломын ажлын зорилго оршино. Энэ зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хувьцаат компаний санхүүгийн тайланд шинжилгээ хийх ерөнхий үзүүлэлтүүд болон арга зүйг онолын үндсэн дээр тодорхойлох;
2. МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниудын санхүүгийн тайлангийн мэдээллийг цуглуулж нэгтгэн, санхүүгийн харьцааны болон эрсдэлийн шинжилгээ хийж, дүгнэх;
3. Монголын хувьцаат компаниудын хувьд тохиромжтой дампуурлын эрсдэлийг тодорхойлох Z загварыг шинээр боловсруулах боломжийг тодорхойлох;
4. Нэгдсэн дүгнэлт гаргах.

Сэдвийн ач холбогдол: Манай орны хувьд санхүүгийн шинжилгээг хийж дүгнэлт гаргахад тулгардаг нэг бэрхшээл нь салбарын дундаж үзүүлэлт байдаггүй асуудал юм. Өмнөх оны төгсөгчид барилгын салбарын дундаж үзүүлэлт, уул уурхайн салбарын дундаж үзүүлэлт тооцсон байдаг. Мөн санхүүгийн тайлангийн шинжилгээний хэрэглээ, тулгамдсан асуудал, систем үзүүлэлтүүдийн онцлогыг тодорхойлох гэх мэт сэдвээр магистрын ажлууд хийсэн боловч ихэвчлэн эмпирик судалгаандаа ганц эсвэл хоёр компанийг жишээ болгон сонгон авчээ. Энэ нь мэдээж манай аж ахуй нэгж, байгууллагууд санхүүгийн тайлангаа нууцладаг, мэдээллийн олдоц муу байдагтай холбоотой. Харин 2011 оноос МХБ нь Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтран дэлхийн жишигт нийцэхүйц хөгжилд хүрэхээр ажилласны үр дүнд 2012 онд хувьцаат компаниудын санхүүгийн тайлан нийтэд ил тод болсон. Иймд энэ судалгааны ажлаар хувьцаат компаниудыг 5-н салбарт хуваан санхүүгийн харьцааны үзүүлэлтүүдийн дундажыг тооцсон. Дундаж үзүүлэлтийг хувьцаат компаниуд санхүүгийн тайлангийн шинжилгээндээ үнэлэлт, дүгнэлт өгөхөд ашиглах бөгөөд өөрсдийн компанийг салбарын түвшинд ямар байр суурьтай байгааг мэдэх боломжтой.

Мөн энэхүү ажил нь МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниудын 2010, 2011, 2012 оны жилийн эцсийн тайлан мэдээнд үндэслэн тэдгээр компаниудын санхүүгийн харьцааны шинжилгээгээр салбарын дундаж үзүүлэлтийг он тус бүрээр тооцсон судалгаа анх удаа хийгдсэн шинэлэг талтай.

Сэдвийн судлагдсан байдал: Ц.Аюурзана, Д.Моломжамц, Б.Сайнжаргал нарын бүтээлд санхүүгийн шинжилгээний үүсэл хөгжлөөс эхлээд арга аргачлал, систем үзүүлэлтүүд, шинжилгээ хийхэд тулгарч буй асуудал зэрэг нь нарийн тусгагдсан байдаг. Мөн энэ сэдвээр 2007 онд МУИС-ийн оюутан С.Цолмон бакалаврын дипломын ажил бичсэн бөгөөд МХБ-д бүртгэлтэй 217 компанийг хамруулсан, эрсдэлийн шинжилгээний аргагүйг сайжруулсан зэрэг нь тухайн ажлын давуу тал болсон байна.

2012 онд Ө.Батзориг магистрын дипломын ажилдаа барилгын салбарын санхүүгийн харьцааны дундаж үзүүлүүлэлтүүдийг тооцож тус салбарт тохирсон дампуурах эрсдлийг тооцох загварыг боловсруулсан байна.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниудын 2010, 2011, 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ашигласан.

Судалгааны арга аргачлал: 2010 оны 78 хувьцаат компани, 2011 оны 202 хувьцаат компани, 2012 оны 200 хувьцаат компанийг судалгаанд хамруулсан. Судалгаанд хамрагдсан хувьцаат компаниудыг МХБ-ын ангилснаар Уул уурхай, Аж үйлдвэр, Хөдөө аж ахуй, Барилга тээвэр, Худалдаа үйлчилгээ гэсэн 5 салбарт хувааж, санхүүгийн харьцааны дундаж үзүүлэлтүүдийг тооцож гаргасан.

Эдийн засгийн судалгааны зэрэгцүүлэх, бүлэглэх, индукци, дедукци, нэгтгэн дүгнэх аргуудыг судалгаанд ашигласан.

Санхүүгийн шинжилгээний үзүүлэлтүүдийг томъёололын дагуу *Microsoft Excel 2010* болон *Eviews 7* програмаар тооцож гаргасан.

Судалгааны ажлын бүтэц: Тус дипломын ажил нь ерөнхий хоёр бүлэгтэй бөгөөд оршил, дүгнэлт, хавсралт зэргээс бүрдсэн. Нэгдүгээр бүлэгт санхүүгийн шинжилгээний талаарх онолын ойлголт арга аргачлалыг гурван дэд гарчигт хуваан оруулсан. Хоёрдугаар бүлэгт судалгаанд хамрагдсан хувьцаат компаниудын санхүүгийн тайланд хийсэн харьцааны шинжилгээ, түүнээс салбарын дундаж үзүүлэлт тооцсон тооцоо мөн санхүүгийн эрсдэлийн шинжилгээний үр дүн багтана.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХУВЬЦААТ КОМПАНИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

1.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГАЗҮЙ

Б.Сайнжаргалын тодорхойлсноор:

Санхүүгийн тайлангийн шинжилгээ нь санхүүгийн менежментийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь бөгөөд удирдлагын шийдвэр гаргаж хэрэгжүүлэх гүйцэтгэлийг үнэлж дүгнэхэд хэрэглэгддэг арга барилуудын нэгдэл юм. Санхүүгийн шинжилгээний үндсэн бааз нь санхүүгийн бүртгэл тайлангийн мэдээлэл байдаг.¹

Санхүүгийн тайлангийн шинжилгээгээр тухайн компаний өнгөрсөн хугацаанд болон өнөөгийн санхүүгийн нөхцөл байдал нь ямар түвшинд явж байгааг, цаашид ямар асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай болохыг илрүүлнэ. Түүнчлэн санхүүгийн шинжилгээ нь компанийн ирээдүйн төлөвлөлтийг хийх үндэс болж өгдөг.

Санхүүгийн тайлангийн шинжилгээний ажлын дэс дараалал

“Шинжилгээний хамрах хүрээ, онцлог, судлах зүйл, зорилго чиглэл, цаашдын хөгжлийн чиг хандлага, өөрийн орны бүртгэл тайлангийн онцлог, өнөөгийн эрэлт хэрэгцээ шаардлага зэргийг харгалзан санхүүгийн тайлангийн шинжилгээг тодорхой төлөвлөгөө ба хөтөлбөрийн хүрээнд явуулах ёстой. Шинжилгээний ажлын дэс дараалал, зохион байгуулалтын түвшингээс шинжилгээний эцсийн үр дүн ихээхэн шалтгаална.”²

Санхүүгийн тайлангийн шинжилгээний ажлын төлөвлөгөөнд:

- 1.Шинжилгээний үндсэн зорилго, чиглэлийг тодорхойлох
- 2.Шинжилгээний ажлын хамрах хүрээг тогтоох
- 3.Шинжилгээнд ашиглагдах бүртгэл санхүүгийн мэдээ тайлангууд, түүнийг шалгах ба боловсруулах арга хэлбэрийг зааж өгөх
- 4.Шинжилгээний ажлын эхлэх, дуусах, үргэлжлэх хугацааг тогтоох
- 5.Шинжилгээний ажлын дэс дараалал, явуулах арга, ашиглах техник хэрэгслийг тодорхойлох буюу хөтөлбөр бэлдэх
- 6.Шинжилгээний ажлыг хаанаас хэн эрхлэн гүйцэтгэхийг тодорхойлох
- 7.Шинжилгээний эцсийн үр дүнг үндэслэн үйл ажиллагаанд нэгдсэн үнэлэлт

¹ Б.Сайнжаргал. 1999 он. *Санхүүгийн тайлангийн шинжилгээ*. хуудас 5

² Д.Моломжамц. 2012 он. *Санхүүгийн Шинжилгээ*. хуудас 122

дүгнэлт өгөх журам зэргийг тус тус зааж өгсөн байна.³

Санхүүгийн шинжилгээ нь аж ахуйн үйл ажиллагааны иж бүрэн шинжилгээний нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Аж ахуйн үйл ажиллагааны иж бүрэн шинжилгээний бүтэц бүрэлдэхүүн, тэдгээрийн уялдаа холбоо, хамрах хүрээ ба агуулгыг Схем 1.1-д дүрслэн харуулав.⁴

Схем 1.1 Аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээний бүтэц



Эх үүсвэр: Д.Моломжамц. 2012 он. *Санхүүгийн Шинжилгээ*. хуудас 194

³ Д.Моломжамц. 2012 он. *Санхүүгийн Шинжилгээ*. хуудас 122-123

⁴ Д.Моломжамц. 2012 он. *Санхүүгийн Шинжилгээ*. хуудас 194

Санхүүгийн тайлангийн хэвтээ шинжилгээ

Санхүүгийн тайланд хийх хэвтээ буюу горизонталь шинжилгээг нэг болон хэд хэдэн хэлбэрээр, абсолют үзүүлэлтүүдийн харьцангуй өсөлтийн хурдыг тооцоолох замаар гүйцэтгэнэ.⁵

Суурь үзүүлэлтээс дараагийн хэд хэдэн жилд өссөн өсөлтийн хурд нь зөвхөн үзүүлэлт тус бүрийн өөрчлөлтийг харуулаад зогсохгүй үзүүлэлтүүдийн цаашдын динамик өөрчлөлтийг урьдчилан тооцоолох боломж олгодог. Харин хэвтээ шинжилгээний ач холбогдол нь инфляцийн нөхцөлд буурдаг байна.⁶

Санхүүгийн тайлангийн босоо шинжилгээ

Аж ахуйн нэгжийн хөрөнгө, түүний эх үүсвэрийг бүтцээр нь шинжлэхийг вертикаль буюу босоо шинжилгээ гэнэ. Босоо шинжилгээг явуулж байгаа зорилгоос нь хамааруулан хоёр ангилж үздэг.⁷ Үүнд :

1. Ашиглагдаж байгаа нөөц болон бусад объём хэмжээний үзүүлэлтүүдээрээ ялгаатай пүүс компаниудын үйл ажиллагааны үр дүн, аж ахуй хоорондын эдийн засгийн потенциалыг харьцуулах ;
2. Санхүүгийн тайлангийн абсолют үзүүлэлтүүдийг гажуудуулах ялангуяа түүний динамик өсөлтийг нь харьцуулахад түвэгтэй болгодог инфляцийн сөрөг нөлөөллийг тодорхой түвшинд багасгах зэрэг болно.

Харьцааны шинжилгээ

Компанийн үйл ажиллагааны түвшинг шинжилж үнэлэхийн тулд санхүүгийн харьцаа коэффициентуудыг тооцдог. Санхүүгийн харьцаануудыг тооцоход тайлан баланс ба орлогын тайлангийн үзүүлэлтүүдийг ашиглана. Компанийн үйл ажиллагааны талаар бодитой үнэлэлт дүгнэлт хийхэд харьцуулан шинжлэх арга үр дүнтэй байдгаараа онцлогтой.⁸

Компанийн хувьцаа эзэмшигчид болон сонирхогчид компанийн эрсдлийн ба өгөөжийн түвшинг анхааралтай ажиглаж байдаг бол зээлдүүлэгчид төлбөрийн чадвар, ашигт ажиллагааг сонирхдог байна. Удирдлагуудын хувьд компанийн санхүүгийн харьцаануудыг тооцож гаргаж болох ч хамгийн чухал харьцааны шинжилгээгээр

⁵ Д.Моломжамц. 2012 он. *Санхүүгийн Шинжилгээ*. хуудас 126

⁶ Д.Моломжамц. 2012 он. *Санхүүгийн Шинжилгээ*. хуудас 126

⁷ Д.Моломжамц. 2012 он. *Санхүүгийн Шинжилгээ*. хуудас 127

⁸ Б.Бүжинлхам. 2012он. *Санхүүгийн удирдлага*. хуудас 155

тооцож гаргасан коэффициентууд юуг илэрхийлж байгааг тодорхойлох нь чухал. Харьцаа өндөр гарч байна уу эсвэл хэт бага байна уу, энэ нь эерэг үзүүлэлт үү, сөрөг үзүүлэлт үү, гэдгийг тодорхойлохын тулд ямар нэгэн дундаж, стандарт эсвэл харьцуулах шалгуур хэрэгтэй болно. Иймээс санхүүгийн харьцаануудыг тооцож гаргаад тэдгээрийг харьцуулан шинжлэх аргатай хослуулан хэрэглэдэг. Харьцуулсан шинжилгээний түгээмэл хэлбэрүүд нь:

- Салбарын харьцуулсан шинжилгээ
- Цаг хугацааны харьцуулсан шинжилгээ байдаг.⁹

Салбарын харьцуулсан шинжилгээг хийхдээ компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийг өрсөлдөгчтэй нь, салбарын дундаж үзүүлэлттэй, тухайн салбарын компанийн үзүүлэлттэй харьцуулна. Үүний үр дүнд дундаж норм буюу стандартаас компанийн үзүүлэлт хэр зэрэг хазайлттай байгааг тодорхойлно. Энэ нь компанийн үйл ажиллагаанд ямар нэгэн асуудал, хүндрэл оршиж байгааг илэрхийлэх ба цаашид тайлангуудад нарийвчилсан шинжилгээ хийсний дүнд асуудлын шалтгааныг тодорхойлно. (Б.Бүжинлхам. 2012. хуудас 156)

Цаг хугацааны харьцуулсан шинжилгээгээр компанийн үйл ажиллагааны үр дүнгээр өнгөрсөн ба өнөө үеийг харьцуулан шинжилж үнэлгээ өгдөг. Иймээс үйл ажиллагааны явцын чиг хандлагыг тодорхойлох боломж бий болох ба үүн дээр үндэслэн компанийн хэтийн төлөвийг тодорхойлно. (Б.Бүжинлхам. 2012. хуудас 156)

Компанийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхдөө салбарын ба хугацааны харьцуулсан шинжилгээг хослуулан хэрэглэх нь илүү үр дүнтэй. Ингэснээр тухайн салбарын хөгжлийн чиг хандлага ба компанийн үйл ажиллагааны явцыг харьцуулан дүгнэх боломж бий болно.¹⁰

Харьцааны шинжилгээг хийхэд анхаарвал зохих дараах зүйлс байдаг.

1. Тооцож гаргасан ганц харьцаа компанийн үйл ажиллагааг үнэлж дүгнэхэд хангалттай мэдээлэл болж чадахгүй бөгөөд хэсэг бүлэг харьцаануудыг авч үзэж байж сая бодитой үр дүнг бий болгож болно.
2. Шинжилгээнд ашиглаж буй санхүүгийн тайлангууд цаг хугацааны хувьд тохирч байх ёстой. Эс тэгвэл үр дүнд нь бодитой болж чадахгүй.

⁹ Б.Бүжинлхам. 2012он. *Санхүүгийн удирдлага*. хуудас 155-156

¹⁰ Б.Бүжинлхам. 2012он. *Санхүүгийн удирдлага*. хуудас 156

3. Санхүүгийн шинжилгээнд ашиглаж буй үзүүлэлтүүд тоо баримтууд үнэн бодитой эсэхэд итгэлтэй байхын тулд хөндлөнгийн хяналтын байгууллагаар баталгаажуулсан тайлан тэнцлийг ашиглах нь зүйтэй.
4. Харьцуулсан шинжилгээнд ашиглах тайлангууд нь нэгдсэн нэг аргачлалаар хийгдсэн байх ёстой.
5. Хугацааны харьцуулсан шинжилгээ хийж байх явцад инфляцийн нөлөөллийг хайхрахгүй байж болохгүй. Тухайлбал өнгөрсөн үеийн бараа материалын нөөцийн хэмжээнээс өнөөгийн нөөцийн хэмжээ асар их зөрүүтэй байхад энд үнийн өсөлтийн нөлөөлөл орсныг үгүйсгэх аргагүй юм. Иймээс инфляцийн нөлөөллийг тооцох хэрэгтэй болно.¹¹

Сангийн сайдын 2001 оны 133 тоот тушаал болох “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал”-аар шинжилгээнд хамаарах сэдвүүдийг эдийн засгийн агуулгаар нь дараах байдлаар ангилсан байдаг.

Үүнд:

1. Хөрөнгө, өр төлбөр эзэмшигчийн өмчийн бүрэлдэхүүн, динамикийн шинжилгээ
2. Төлбөрийн чадварын шинжилгээ
3. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ
4. Эргэцийн шинжилгээ
5. Бүтээмжийн шинжилгээ
6. Үндсэн хөрөнгийн шинжилгээ
7. Орлого, үр дүнгийн шинжилгээ
8. Ашигт ажиллагааны шинжилгээ
9. Зах зээлийн идэвхижилын шинжилгээ
10. Мөнгөн урсгалын шинжилгээ¹²

¹¹ Б.Бүжинлхам. 2012он. *Санхүүгийн удирдлага*. хуудас 156-157

¹² Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал. 2001 он. Электрон эх үүсвэр: www.sanhuu.mn

1.2 САНХҮҮГИЙН ХАРЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Санхүүгийн шинжилгээнд ашиглагдах санхүүгийн харьцаануудыг дараах бүлгүүдэд хуваадаг. Үүнд:

1. Хөрвөх чадварын харьцаа
2. Үйл ажиллагааны харьцаа
3. Ашигт ажиллагааны харьцаа
4. Өрийн харьцаа зэрэг багтана.¹³

Хөрвөх чадварын шинжилгээ

Хөрвөх чадварын харьцаа нь компаний богино хугацааны төлбөрийн чадварыг харуулдаг. Хөрвөх чадвар бол компаний санхүүгийн байдал, төлбөрийн чадварын хэмжүүр болдог.¹⁴

Компаний хөрвөх чадварыг дараах үзүүлэлтүүдээр хэмждэг. Үүнд:

- Ажлын цэвэр капитал
- Эргэлтийн харьцаа
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа
- Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа

Ажлын цэвэр капитал:

$$\text{АЦК} = \text{Эргэлтийн хөрөнгө} - \text{Эргэлтийн эх үүсвэр}$$

(Б.Бүжинлхам. 2012он. хуудас 159)

Ажлын цэвэр капитал нь мөнгөн дүнгээр илэрхийлэгддэг учир энэ үзүүлэлтийг бусад компанийн үзүүлэлттэй харьцуулахад, өөрөөр хэлбэл салбарын харьцуулсан шинжилгээнд ашиглахад төдийлөн тохиромжтой бус. Харин компанийн өнгөрсөн ба өнөөгийн үеийн хөрвөх чадварын түвшинг харьцуулан шинжлэхэд чухал ач холбогдол бүхий үзүүлэлт болно. АЦК-г бусад компанийн үзүүлэлттэй харьцуулахын тулд борлуулалтын хувиар илэрхийлэн тооцож болно.

$$\text{АЦК}\% = \frac{\text{АЦК}}{\text{Борлуулалт}}$$

Энэ үзүүлэлт өндөр байх нь хөрвөх чадвар сайн байгааг илэрхийлнэ.¹⁵

Эргэлтийн харьцаа:

¹³ Ж.Пүрэвсүрэн. 2007 он. *Санхүүгийн удирдлага*. хуудас 76

¹⁴ Б.Бүжинлхам. 2012он. *Санхүүгийн удирдлага*. хуудас 159

¹⁵ Б.Бүжинлхам. 2012он. *Санхүүгийн удирдлага*. хуудас 159-160

Эргэлтийн харьцаа нь богино хугацаат өр төлбөрөө эргэлтийн хөрөнгөө ашиглан төлөх чадвар ямар байгааг илэрхийлнэ.¹⁶

$$\text{ЭХ} = \frac{\text{Эргэлтийн хрнг}}{\text{Богино хугацаат р тлбр}}$$

(Б.Бүжинлхам. 2012он. хуудас 159)

Эргэлтийн харьцаа 1-ээс бага бол төлбөрийн чадваргүй, 2-3 байвал оновчтой тоон утга, 3-аас их байвал төлбөрийн чадвар сайн ч ашиглалтгүй хөрөнгө байгааг харуулна.¹⁷

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа:

Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа нь төлбөрийг барагдуулахад нэн түрүүнд дайчлагдах хөрөнгүүд нь хүрэлцэхүйц байгаа эсэхийг илэрхийлэх бөгөөд утга нь 0.8-1.0 орчим, үүнээс багагүй байвал зохино гэж үздэг. Эргэлтийн харьцаатай төстэй ч гагцхүү эргэлтийн хөрөнгөөс бараа материалын нөөцийг хассан дүнг эргэлтийн эх үүсвэртэй харьцуулдагаараа ялгаатай. Төлбөр түргэн гүйцэтгэх гэсэн утгаараа хамгийн хөрвөх чадвар сайтай хөрөнгүүдийг авч, хөрвөх чадвар хамгийн багатай хөрөнгө болох бараа материалын нөөцийг тооцохгүй орхидог.¹⁸

$$\text{ТТГЧХ} = \frac{\text{Мнгн хрнг} + \text{Богино хугацаат хөрөнгө оруулалт} + \text{Авлага}}{\text{Богино хугацаат р тлбр}}$$

(Б.Сайнжаргал. 1999 он. хуудас 32)

Үнэмлэхүй хөрвөх чадварын харьцаа:

Үнэмлэхүй хөрвөх чадварын харьцаа нь төлбөр барагдуулах өнөөгийн боломж буюу богино хугацаат өр төлбөрийн хэдэн хувийг нь барагдуулж чадах мөнгөтэй байгааг илэрхийлнэ. Энэ харьцаа нь 0.2 буюу 20 хувиас доошгүй байвал зохистой хэмжээнд байна гэж үздэг.¹⁹

$$\text{ХЧХ} = \frac{\text{Мнгн хрнг} + \text{Богино хугацаат хрнг оруулалт}}{\text{Богино хугацаат р тлбр}}$$

(Б.Сайнжаргал. 1999 он. хуудас 33)

¹⁶ Б.Бүжинлхам. 2012он. *Санхүүгийн удирдлага*. хуудас 160

¹⁷ Ж.Пүрэвсүрэн. 2007 он. *Санхүүгийн удирдлага*. хуудас 77

¹⁸ Б.Сайнжаргал. 1999 он. *Санхүүгийн тайлангийн шинжилгээ*. хуудас 33

¹⁹ Б.Сайнжаргал. 1999 он. *Санхүүгийн тайлангийн шинжилгээ*. хуудас 33

Үйл ажиллагааны шинжилгээ

Үйл ажиллагааны харьцаанууд нь компанид янз бүрийн хэлбэрээр байршсан хөрөнгө ба эх үүсвэрүүдийн борлогдох эсвэл мөнгө болж ирэх хурдыг тодорхойлно. Үйл ажиллагааны харьцаанууд нь тодорхой дансуудын хөрвөх чадварыг илэрхийлдэг гэж үзэж болно.²⁰

Мөн үйл ажиллагааны шинжилгээ нь байгууллага өөрийн хөрөнгөө хэрхэн үр дүнтэй зохион байгуулж буйг үнэлнэ. Дараах харьцаануудаар үнэлнэ. Үүнд:

- Бараа материалын эргэлт
- Авлага цуглуулах дундаж хугацаа
- Төлбөр төлөх дундаж хугацаа
- Ажлын капиталын эргэлт
- Нийт хөрөнгийн эргэлт
- Үндсэн хөрөнгийн эргэлт
- Үйлдвэрлэлийн циклийн хугацаа
- Бэлэн мөнгөний эргэлтийн цикл /өдрөөр/

Бараа материалын эргэлт:

Энэ үзүүлэлт нь бараа материалыг хэр хурдан борлуулж байгааг хэмждэг үзүүлэлт юм. Бараа материалын эргэлт түргэсхийн хэрээр борлуулалт сайжирч, мөнгөн орлого нэмэгдэх нөхцөл бүрддэг. Гэхдээ бас бараа материалын хомсдлоос энэ эргэцийн харьцаа удааширч болох юм.

$$\text{Бараа материалын эргэлт (удаа)} = \frac{\text{ББӨ эсвэл Борлуулалт}}{\text{Бараа материалын дундаж}}$$

$$\text{Бараа материалын дундаж наслалт} = \frac{365}{\text{БМЭ (удаа)}}$$

(Б.Бүжинлхам. 2012он. хуудас 162)

Авлага цуглуулах дундаж хугацаа:

Авлага цуглуулах дундаж хугацаа нь дансны авлага үүсэж бий болоод төлөгдөж орж ирэх хүртэлх дундаж хугацааг илэрхийлнэ.

$$\text{Авлагын эргэлт} = \frac{\text{Борлуулалт}}{\text{Авлага}}$$

$$\text{Авлага цуглуулах дундаж хугацаа} = \frac{365}{\text{Авлагын эргэлт}}$$

²⁰ Б.Бүжинлхам. 2012он. Санхүүгийн удирдлага. хуудас 161

(Б.Бүжинлхам. 2012он. хуудас 162)

Төлбөр төлөх дундаж хугацаа /өдрөөр/:

Өглөгийн төлбөрийн дундаж хугацааны харьцаа нь өглөг үүсэж бий болсноос хойш төлөгдөж дуусах хүртэлх хугацааг илэрхийлнэ.

$$\text{Өглөгийн эргэлт} = \frac{\text{Борлуулалт}}{\text{Дансны глг}}$$

$$\text{Тлбр тлх дундаж хугацаа} = \frac{365}{\text{глгийн эргэлт}}$$

(Б.Бүжинлхам. 2012он. хуудас 163)

Үйл ажиллагааны цикл:

Үйл ажиллагааны цикл = АЦДХ + Бараа материалын дундаж наслалт

(Ж.Пүрэвсүрэн. 2007 он. хуудас 103)

Бэлэн мөнгөний эргэлтийн цикл /өдрөөр/:

Компани үйл ажиллагаандаа ашигласан бэлэн мөнгийг үйл ажиллагааныхаа үр дүнд бий болсон бэлэн мөнгө болох хүртэлх хугацааг санхүүгийн хэмжигдэхүүнээр хэмждэг.

Бэлэн мөнгөний эргэлтийн цикл = Үйл ажиллагааны цикл – ТТДХ

(Ж.Пүрэвсүрэн. 2007 он. хуудас 104)

Үндсэн хөрөнгийн эргэлт:

Энэ харьцаанд машин тоног төхөөрөмжийн хүчин чадлыг хэр зэрэг үр дүнтэй ашиглаж байгааг харуулна. Үндсэн хөрөнгө нь ашиг бүтээгч хөрөнгө тул эргэц өндөр байх нь хөрөнгийн үр ашиг өндөр байгааг илтгэнэ.

$$\text{Үндсэн хөрөнгийн эргэлт} = \frac{\text{Борлуулалт}}{\text{Үндсэн хөрөнгө}}$$

(Ж.Пүрэвсүрэн. 2007 он. хуудас 79)

Нийт хөрөнгийн эргэлт:

Энэ харьцаа нь компаний нийт хөрөнгийн эргэц болон үр ашгийг илэрхийлнэ.

$$\text{Нийт хрнгийн эргэлт} = \frac{\text{Борлуулалт}}{\text{Нийт хрнгө}}$$

(Ж.Пүрэвсүрэн. 2007 он. хуудас 79)

Ашигт ажиллагааны шинжилгээ

Бизнесийн эцсийн зорилго нь ашиг олох явдал бөгөөд оруулсан хөрөнгийг илүү үр бүтээлтэй ашиглаж орлогоороо зардлаа нөхөж ашигтай ажилласан нөхцөлд үйл ажиллагаагаа өргөтгөх боломжтой болно. Ашигт ажиллагааны үнэлгээ нь эдийн засгийн үр ашгийн нэгдсэн үзүүлэлт бөгөөд оруулсан хөрөнгө, капиталын нэгж тутамд олсон ашгийн хэмжээг мөнгөөр илэрхийлдэг чухал үзүүлэлт юм.²¹

Ашигт ажиллагааны бүлэг үзүүлэлтүүдээс дараах үзүүлэлтүүд практикт түгээмэл хэрэглэгддэг. Үүнд

- Үйл ажиллагааны ахиуц ашиг
- Ахиуц цэвэр ашиг
- Хувьцаат капиталын өгөөж
- Хөрөнгө оруулалтын өгөөж

Үйл ажиллагааны ахиуц ашиг:

Үйл ажиллагааны ахиуц ашиг нь үйл ажиллагааны зардлуудыг төлсний дараагаар үлдэж буй борлуулалтын орлогын хэмжээг харуулна.²²

Ахиуц нийт ашиг нь өндөр байвал нийт борлуулсан бүтээгдэхүүний өртөг бага, ахиуц нийт ашиг нь бага байвал борлуулсан бүтээгдэхүүний өртөг өндөр байгааг илэрхийлдэг.

$$\text{йл ажиллагааны ахиуц ашиг} = \frac{\text{йл ажиллагааны ашиг}}{\text{Борлуулалт}}$$

(Б.Бүжинлхам. 2012он. хуудас 170)

Ахиуц цэвэр ашиг:

Ахиуц цэвэр ашиг нь тавар болон бусад бүх зардлуудаа төлөөд үлдсэн борлуулалтын орлогын хэсгийг хэлнэ.

$$\text{Ахиуц цэвэр ашиг} = \frac{\text{Татварын дараах цэвэр ашиг}}{\text{Борлуулалт}}$$

(Б.Бүжинлхам. 2012он. хуудас 170)

Хувьцаат капиталын өгөөж:

Энэ харьцаа нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн 1 төгрөг тутамд ноогдож буй ашгийн хэмжээг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл хувьцаат капиталын өгөөжийн харьцаа юм.

²¹ Д.Моломжамц. 2012 он. *Санхүүгийн Шинжилгээ*. хуудас 162

²² Б.Бүжинлхам. 2012он. *Санхүүгийн удирдлага*. хуудас 170

$$\text{Хувьцаат капиталын гж} = \frac{\text{Татварын дараах цэвэр ашиг}}{\text{Эзэмшигчийн өмч}}$$

(Б.Бүжинлхам. 2012он. хуудас 171)

Хөрөнгө оруулалтын өгөөж:

Хөрөнгө оруулалтын өгөөжийг мөн нийт хөрөнгийн өгөөж гэж нэрлэдэг. Нийт хөрөнгийн 1 төгрөг тутамд ногдож байгаа цэвэр ашгийн хэмжээг илэрхийлнэ. Хөрөнгө оруулалтын өгөөж өсвөл ашигт ажиллагаа мөн өснө.

$$\text{Хөрөнгө оруулалтын өгөөж} = \frac{\text{Татварын дараах цэвэр ашиг}}{\text{Нийт хөрөнгө}}$$

(Б.Бүжинлхам. 2012он. хуудас 171)

Үнэ ашгийн харьцаа:

Үнэ ашгийн харьцаа нь зах зээл компаний 1 төгрөгийн ашгийн төлөө төлөхөд бэлэн байгаа мөнгөний хэмжээг илэрхийлнэ. Мөн зах зээл компаний хэтийн төлөвийг үнэлж байгаа үнэлгээний хэмжүүр болдог. Үнэ ашгийн харьцаа өндөр байх тусам компани зах зээлд нэр хүндтэй, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтанд итгэх итгэл өндөр байгаагийн илрэл болдог.

$$\text{Үнэ ашгийн харьцаа} = \frac{\text{Хувьцааны зах зээлийн үнэ}}{\text{Нэгж хувьцаанд ногдох ашиг}}$$

(Б.Бүжинлхам. 2012он. хуудас 172)

Өрийн шинжилгээ

Компаний хувьд “өр зээл” бол ашиг олохын тулд хэрэглэж байгаа “өөр хүмүүсийн мөнгө” юм. Зээлдэгчдийн өр төлбөрийг хувьцааны ногдол ашиг олгохоос өмнө төлж барагдуулах учир хувьцаа эзэмшигчид ба хөрөнгө оруулагчид компаний өр зээлийн түвшинд онцгой анхаарал хандуулдаг. Компаний нийт хөрөнгөд өр зээлийн эзлэх хувь өндөр байх тусам санхүүгийн хөшүүрэг өндөр болно. Санхүүгийн хөшүүрэг нь зээл, онцгой эрхт хувьцаа зэрэг тогтмол зардалтай эх үүсвэр ашиглаж байгаатай холбоотойгоор үүсдэг ба эрсдлийн хэмжүүр болдог.²³

- Өрийн харьцаа
- Хүү төлөх чадварын харьцаа
- Өр барагдуулах өнөөгийн боломж

²³ Б.Бүжинлхам. 2012он. *Санхүүгийн удирдлага*. хуудас 164

- Өр барагдуулах ойрын боломж

Өрийн харьцаа:

Өрийн харьцаа нь нийт эх үүсвэр дотор зээлийн эх үүсвэрийн эзлэх хувь буюу нийт хөрөнгийн дотор зээлийн эх үүсвэрээр санхүүжигдэж байгаа хэсгийн хувь хэмжээг илэрхийлнэ.

$$\text{рийн харьцаа} = \frac{\text{Нийт р тлбр}}{\text{Нийт хрнг}}$$

(Б.Бүжинлхам. 2012он. хуудас 166)

Хүү төлөх чадварын харьцаа:

Тус үзүүлэлт өндөр байх нь тухайн компани хүүгийн төлбөрөө хурдан төлж дуусгах боломжийг олгох юм. Уг харьцаа 3-аас дээш байх тохиолдолд хэвийн гэж үзнэ.

$$\text{Х тлх чадварын харьцаа} = \frac{\text{Х, татварын мнх ашиг}}{\text{Хний зардал}}$$

$$\text{Өр барагдуулах өнөөгийн боломж} = \frac{\text{Мөнгөн хөрөнгө}}{\text{БХӨТ}}$$

$$\text{Өр барагдуулах ойрын боломж} = \frac{\text{Мөнгөн хөрөнгө} + \text{Авлага}}{\text{БХӨТ}}$$

(Б.Бүжинлхам. 2012он. хуудас 167)

Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ

Санхүүгийн тогтвортой байдал нь юуны өмнө тухайн байгууллагын санхүүгийн нөөцийн бүтэц бүрэлдэхүүн, өөрийн ба гадны капиталын оролцоо (харьцаа)-гоор тодорхойлогдоно.²⁴

Хүснэгт 1.1. Санхүүгийн тогтвортой байдал болон санхүүгийн бие даасан байдлын үзүүлэлт

Үзүүлэлт	Хязгаарлалт	Тайлбар
Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа $K_{zc} = \frac{\text{Нийт өр төлбөр}}{\text{Эзэмшигчийн өмч}}$	<1-1.5	1 төгрөгийн өөрийн хөрөнгөд оногдох өрийн хэмжээг харуулдаг.
Өөрийн хөрөнгөөр санхүүжилт хийх чадвар $K_{cc} = \frac{\text{Эзэмшигчийн өмч} - \text{ЭБХ}}{\text{Эргэлтийн хрнг}}$	Доод хязгаар 0.1, 0.5	Эргэлтийн активын хэдий хэмжээг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж буйг харуулна.
Санхүүгийн хамаарлын коэффициент $K_{fn} = \frac{\text{Эзэмшигчийн мч}}{\text{Нийт хрнг}}$	0.4-0.6	Өөрийн хөрөнгө нийт активт эзлэх хувь харуулна.
Санхүүжилтийн коэффициент $K_{\phi} = \frac{\text{Эзэмшигчийн өмч}}{\text{Нийт өр төлбөр}}$	0.7, оновчтой нь 1.5	Үйл ажиллагааны ямар хэмжээг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж буйг харуулдаг.
Санхүүгийн тогтвортой байдлын коэффициент $K_{\phi y} = \frac{\text{Эзэмшигчийн өмч} + \text{УХТ}}{\text{Нийт хрнг}}$	0.6	Активын ямар хэмжээг тогтвортой эх үүсвэрээр санхүүжүүлж байгааг харуулдаг.

Эх үүсвэр: А.Ганзориг. 2007 он. *Эрсдэлийн удирдлагын лекц*. хуудас 54

²⁴ Б.Сайнжаргал. 1999 он. *Санхүүгийн тайлангийн шинжилгээ*. хуудас 36

1.3 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГАЧИЛАЛ

Санхүүгийн эрсдэлийн шинжилгээний талаар МУИС-ЭЗС-ийн санхүүгийн тэнхимийн багш А.Ганзориг тодорхойлохдоо:

Эрсдэлийн үнэлгээний тогтолцооны үзүүлэлтийг дотор нь мэдээллийн шинж чанараас нь хамааруулж дараах үндсэн гурван хэсэгт ангилдаг байна. Үүнд:

1. Тодорхой нөхцөлтэй /Нөхцөл тодорхой бол эрсдэл тодорхой байдаг. Нягтлан бодох бүртгэл, орлогын тайлан гэх мэт үүний нэг жишээ/

а) Абсолют: Энд эрсдэлийн хэмжээ материал болон, өртгөөр илэрхийлнэ. Мөн тэнцэлийн үзүүлэлтийг ашиглан төлбөр гүйцэтгэх чадвар, гэх мэт үзүүлэлтийг тогтоох үед илэрнэ.

б) Харьцангуй: Харьцангуй хэмжээний үед гарах эрсдэлийг суурь үзүүлэлтэй харьцуулж болохоор байна. Энэ үзүүлэлтийг гол төлөв үндсэн хөрөнгө, эргэлийн хөрөнгө, тухайн жилийн нийт зардал, ашиг гэх мэт үзүүлэлтүүдээр хийгднэ.

с) Дундаж: Энэ үзүүлэлт нь хялбарчилсан ойлголт юм.

2. Тухайн тодорхой бус нөхцөлтэй /Эрсдэл үүсэх давтамжийн мэдээлэлтэй холбоотой/

а) Магадлалтай /Тухайн тодорхой бус нөхцөлийн магадлалтай шинж гэдэг нь эрсдэл үүсэх нь магадлалтай холбоотой./

б) Статистик /Статистик үзүүлэлтийн үед боломжит төвшнөөс зөрөх хэмжээг харуулдаг. Хамгийн бага мэдээлэлтэй байдаг./

3. Бүрэн тодорхой бус нөхцөлтэй /Бүрэн бус тодорхой байдлын үед эрсдэл үүсэх мэдээлэл шинжээчдэд бүрэн хэмжээгээр тодорхой бус байна/


а) Экспертийн шинжилгээ хийнэ.²⁵

Төлбөрийн чадварын эрсдэлийн үнэлгээ

Балансын хөрвөх чадварыг үнэлэхдээ төлбөрийн хэрэгслийг бэлэн мөнгө болж хөрвөх чадвараар нь харин өр төлбөрийг хүлээгдэж байгаа хугацаагаар нь дараах байдлаар ангилна.

²⁵ А.Ганзориг. 2007 он. *Эрсдэлийн удирдлагын лекц*. хуудас 42-43

Схем 1.2. Активын бүтцийн эрсдэлийн ангилал



Эх үүсвэр: А.Ганзориг. 2007 он. *Эрсдэлийн удирдлагын лекц*. хуудас 45

Схем 1.3. Пассивын бүтцийн эрсдлийн ангилал



Эх үүсвэр: А.Ганзориг. 2007 он. *Эрсдэлийн удирдлагын лекц*. хуудас 51

Бэлэн байгаа төлбөрийн хэрэгсэл болон хүлээгдэж байгаа өр төлбөрийн харьцаагаар төлбөрийн чадварыг тодорхойлдог.

Дээрх актив пассивын ангилалын дараа төлбөр гүйцэтгэх чадварын нөхцөлөө дараах байдлаар шалгаж болно.

Төлбөрийн гүйцэтгэх чадварын нөхцөл

Хүснэгт 1.2. Төлбөрийн чадварыг тодорхойлох үнэлгээ

Төлбөрийн чадварын үзүүлэлт	A1 > П1 A2 > П2 A3 > П3 A4 < П4	A1 < П1 A2 > П2 A3 > П3 A4 < П4	A1 < П1 A2 < П2 A3 > П3 A4 < П4	A1 < П1 A2 < П2 A3 < П3 A4 < П4
Тэнцлийн харьцаа	Абсолют төлбөрийн чадвартай (Оновчтой)	Төлбөрийн чадвар хэвийн (Зөвшөөрөгдөх)	Төлбөрийн чадвар доголдсон (Хангалтгүй)	Төлбөрийн чадвар доголдсон (Зөвшөөрөгдөхгүй)
Төлбөрийн чадварыг тодорхойлох үнэлгээ	Эрсдэлгүй муж	Зөвшөөрөгдөх эрсдэлийн хэмжээний муж	Критик эрсдэлийн муж	Катастроф эрсдэлийн муж

Эх үүсвэр: А.Ганзориг. 2007 он. *Эрсдэлийн удирдлагын лекц*. хуудас 52

A1 > П1, A2 > П2, A3 > П3, A4 < П4 нөхцөлийг хангаж байвал балансын хөрвөх чадвар сайтай ба өр төлбөр, төлбөрийн хэрэгсэл зохистой харилцаанд байна гэж үзнэ.

Энэ үнэлгээний хувьд тухайн аж ахуйн нэгж төлбөрийн чадварыг ижил үйл ажиллагаа бүхий аж ахуйн нэгж болон салбарын дундажтай харьцуулж болно. Ингэж харьцуулахдаа пассивуудын нийт эх үүсвэрт эзлэх хувийн жингээр нь, активуудын мөн адил хувийн жингээр нь тодорхойлж харьцуулах замаар үнэлж өгдөг.

Санхүүгийн тогтвортой байдлын эрсдэлийн үнэлгээ

А.Ганзоригийн тодорхойлсоноор санхүүгийн тогтвортой байдлын эрсдлийг үнэлэхдээ:

1. $\pm\Phi^c$ -Бараа материал болон сэлбэг хэрэгсэл бусад зардал бий болоход шаардагдах өөрийн эргэлтийн хөрөнгийн хүрэлцээ

$$\pm\Phi^c = \text{ЭӨ-ЭБХ-(БМ+Сэлбэг хэрэгсэл)}$$

2. $\pm\Phi^{cd}$ -Бараа материал болон сэлбэг хэрэгсэл бусад зардыг бий болгодог өөрийн хөрөнгө ба урт хугацаатай өрийн хүрэлцээ

$$\pm\Phi^{cd} = \text{ЭӨ+УХӨТ-ЭБХ-(БМ+Сэлбэг хэрэгсэл)}$$

3. $\pm\Phi^o$ -Бараа материал болон сэлбэг хэрэгсэл бусад зардыг бий болгоход зарцуулагдах үндсэн эх үүсвэрийн хүрэлцээ

$$\pm\Phi^o = \text{ЭӨ+УХӨТ+ДӨ-ЭБХ-(БМ+Сэлбэг хэрэгсэл)}$$

$$S(\Phi) = \begin{cases} 1 & \text{хэрэв } \Phi > 0 \\ 0 & \text{хэрэв } \Phi < 0 \end{cases}$$

(А.Ганзориг. 2007 он. хуудас 54)

Хүснэгт 1.3. Санхүүгийн нөхцөл байдлын төрөл, үнэлгээ

Нөхцөл	$\pm\Phi^c \geq 0;$ $\pm\Phi^{cd} \geq 0;$ $\pm\Phi^o \geq 0$ S(={1,1,1})	$\pm\Phi^c < 0;$ $\pm\Phi^{cd} \geq 0;$ $\pm\Phi^o \geq 0$ S(={0,1,1})	$\pm\Phi^c < 0;$ $\pm\Phi^{cd} < 0;$ $\pm\Phi^o \geq 0$ S(={0,0,1})	$\pm\Phi^c < 0;$ $\pm\Phi^{cd} < 0;$ $\pm\Phi^o < 0$ S(={0,0,0})
Санхүүгийн нөхцөл байдлын төрөл	Абсолют тогтвортой	Зөвшөөрдөх тогтвортой	Санхүүгийн тогтворгүй байдал	Санхүүгийн хямрал байдал
Санхүүгийн байдалд өгөх үнэлгээ	Эрсдэлгүй муж	Эрсдэлийн зөвшөөрөгдөх муж	Санхүүгийн тогтворгүй муж	Санхүүгийн хямралын муж

Эх үүсвэр: А.Ганзориг. 2007 он. *Эрсдэлийн удирдлагын лекц*. хуудас 54

Дампуурлын шинжилгээ

АНУ-ын эрдэмтэн Э.А.Альтман 1966 онд Америкийн компаниудын хувьд дампуурлын эрсдэлийг тооцох Z индексийн загварыг тодорхойлсон.

$$Z = 1.2X_1 + 1.4X_2 + 3.3X_3 + 0.6X_4 + 1.0X_5^{26}$$

- X_1 = Ажлын капитал / Нийт хөрөнгө
- X_2 = Хуримтлагдсан ашиг / Нийт хөрөнгө
- X_3 = Татварын өмнөх ашиг / Нийт хөрөнгө
- X_4 = Эзэмшигчийн өмчийн дүн / Нийт өр төлбөр
- X_5 = Цэвэр борлуулалт / Нийт хөрөнгө

$Z < 1.810$ дампуурах магадлал их

$1.810 \leq Z < 2.675$ дампуурах магадлал дунд зэрэг

$Z = 2.675$ дампуурах магадлал 0.5

$2.675 < Z \leq 2.990$ дампуурах магадлал их биш

$Z > 2.990$ дампуурах магадлал бага

Альтманы загвар нь дампуурах магадлалыг 1 жилийн хугацаанд 85-90 хувийн, 3 жил хүртлэх хугацаанд 83 хувийн магадлалтай тооцдог.

²⁶ Edward I. Altman. 1968. *Altman Z-score*. Available at: www.wikipedia.com

Энэ загвар нь АНУ–ын хувьд тохиромжтой боловч Монголын хувьд шууд хэрэглэх нь дутагдалтай байсан учир МУИС-ЭЗС-ийн оюутан С.Цолмон манай орны эдийн засгийн нөхцөлд тохирсон хувьцаат компаниудын дампуурлыг оношлох Z_MGL загварыг 2007 онд тодорхойлсон. С.Цолмонгийн тодорхойлсноор Монголын нөхцөлд дампуурлыг оношлох загвар нь дараах томъёоллоор илэрхийлэгднэ.

$$Z_MGL = 3.330886674 * X1 + 4.45290375 * X3 + 0.4388346042 * X4 + 2.412062128 * X5$$

- $X1$ = Ажлын капитал / Нийт хөрөнгө
- $X3$ = Татварын өмнөх ашиг / Нийт хөрөнгө
- $X4$ = Эзэмшигчийн өмчийн дүн / Нийт өр төлбөр
- $X5$ = Борлуулалтын орлого / Нийт хөрөнгө

1. $Z_MGL > -0.0782$ гарвал дампуурахгүй ба итгэх магадлал нь 100% тай.
2. Хэрэв $-0.17577 < Z_MGL < -0.0783$ гарвал дамдуурах магадлал бага ба энэ нь 98.92%
3. Хэрэв $-0.47818 < Z_MGL < -0.17578$ гарвал дамдуурах магадлалтай ба энэ нь 93.548%
4. $Z_MGL < -0.47819$ гарвал 100% магадлалтайгаар дампуурна. (С.Цолмон. 2007 он. хуудас 11)

Дээрх загварыг МХБ-д хувьцаа нь арилжаалагдаж буй хувьцаат компанийн хувьд тохиромжтой эсэх, цаашид энэ загварыг хэвшүүлэн хэрэглэх боломжтой эсэхийг судалгаагаар тодорхойлох болно.

Дампуурах эрсдэлийг тодорхойлох бусад загварууд:

Э.А.Альтманы 4 хувьсагчтай загвар

$$Z = 6.56X1 + 3.26X2 + 6.72X3 + 1.05X4^{27}$$

- $X1$ = Ажлын капитал / Нийт хөрөнгө
- $X2$ = Хуримтлагдсан ашиг / Нийт хөрөнгө
- $X3$ = Татварын өмнөх ашиг / Нийт хөрөнгө
- $X4$ = Эзэмшигчийн өмчийн дүн / Нийт өр төлбөр

$Z > 2.6$ -“Аюулгүй” бүс

$1.1 < Z < 2.6$ -“Бүрхэг” бүс

$Z < 1.1$ -“Аюултай” бүс

²⁷ Edward I. Altman. 1968. *Altman Z-score*. Available at: www.wikipedia.com

Лисогийн дөрвөн хувьсагчтай загвар

$$Z=0.063X_1+0.092X_2+0.057X_3+0.001X_4^{28}$$

X1-цэвэр эргэлтийн хөрөнгө/нийт актив

X2-хуримтлагдсан ашиг/нийт актив

X3 –татварын өмнөх ашиг/нийт актив

X4-өөрийн хөрөнгө/өр

$Z<0.037$ дампуурах магадлал их

$Z>0.037$ дампуурах магадлал бага

Таффлерийн дөрвөн хувьсагчтай загвар

$$Z=0.53X_1+0.13X_2+0.18X_3+0.16X_4^{29}$$

$Z<0.2$ компаний үйл ажиллагааны хэтийн хөгжил байхгүй болсон

$Z>0.3$ дампуурах магадлал бага

²⁸ А.Ганзориг. 2007 он. *Эрсдэлийн удирдлагын лекц*. хуудас 82

²⁹ А.Ганзориг. 2007 он. *Эрсдэлийн удирдлагын лекц*. хуудас 83

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУВЬЦААТ КОМПАНИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

МХБ-д бүртгэлтэй 329 хувьцаат компани байгаагаас 100 хувь төрийн өмчийн 23 хувьцаат компани, төрийн өмчийн оролцоотой 29 хувьцаат компани, хувийн өмчийн 277 хувьцаат компани байна. Эдгээрээс МХБ-ийн вэбсайтад санхүүгийн тайлан нь нийтлэгдсэн хувьцаат компаниудын 2010, 2011, 2012 оны санхүүгийн тайланд шинжилгээ хийж гүйцэтгэлээ. Хувьцаат компаниудын баланс, орлого үр дүнгийн тайланг нэг хэлбэрт оруулан нэгтгэж санхүүгийн харьцааны болон эрсдэлийн шинжилгээг хийсэн болно. МХБ-ийн вэбсайтад нийтлэгдсэн хувьцаат компаниудын хураангуй болон дэлгэрэнгүй тайланг ашигласан бөгөөд зарим компаниудын тайлангийн алдаатай, дутуу байдал нь тайлангуудыг нэгтгэх явцыг хүндрүүлж байлаа. Түүнчлэн дээрх шалтгааны улмаас баланс, орлого үр дүнгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн 2010 оны 78 хувьцаат компани, 2011 оны 202 хувьцаат компани, 2012 оны 200 хувьцаат компанийг судалгаанд хамруулсан. Судалгаанд хамрагдсан хувьцаат компаниудыг МХБ-ын ангилснаар Уул уурхай, Аж үйлдвэр, Хөдөө аж ахуй, Барилга тээвэр, Худалдаа үйлчилгээ гэсэн 5 салбарт хувааж, доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2.1 Судалгаанд хамрагдсан хувьцаат компаниудын салбарын ангилал

Код	Салбарын нэр	Судалгаанд хамрагдсан хувьцаат компаниудын тоо		
		2010 он	2011 он	2012 он
A	Уул уурхай	16	39	36
B	Аж үйлдвэр	19	37	40
C	Хөдөө аж ахуй	5	28	32
D	Барилга тээвэр	20	58	53
E	Худалдаа үйлчилгээ	18	40	39
	Нийт	78	202	200

Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

2.1 ХУВЬЦААТ КОМПАНИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХАРЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хүснэгт 2.2 Харьцааны шинжилгээний ангилал, томъёолол

	Үзүүлэлт	Тооцооны томъёо
<i>Хөрвөх чадварын шинжилгээ</i>		
1	Ажлын цэвэр капитал (борлуулалтад харьцуулсан)	АЦК/ЦБ
2	Эргэлтийн харьцаа	ЭХ/БХӨТ
3	Төлбөрийн чадварын харьцаа	(ЭХ-БМ)/БХӨТ
4	Үнэмлэхүй хөрвөх чадварын харьцаа	(МХ+БХХО)/БХӨТ
<i>Үйл ажиллагааны шинжилгээ</i>		
5	Бараа материалын эргэлт	ЦБ/БМ
6	Бараа материалын дундаж наслалт	365/БМЭ
7	Авлагын эргэлт	ЦБ/Авлага
8	Авлага цуглуулах дундаж хугацаа	365/Авлагын эргэц
9	Өглөгийн эргэлт	ЦБ/Дансны өглөг
10	Төлбөр төлөх дундаж хугацаа	365/Өглөгийн эргэц
11	Үйл ажиллагааны цикл	АЦДХ+БМДН
12	Бэлэн мөнгөний цикл	ҮАЦ-ТТДХ
13	Үндсэн хөрөнгийн эргэлт	ЦБ/ЭБХ
14	Нийт хөрөнгийн эргэлт	ЦБ/НХ
<i>Өрийн шинжилгээ</i>		
15	Өрийн харьцаа	ӨТ/НХ
16	Хүү төлөх чадварын харьцаа	Хүү, ТӨА/Хүүний зардал
17	Өр барагдуулах өнөөгийн боломж	МХ/БХӨТ
18	Өр барагдуулах ойрын боломж	(МХ+Авлага)/БХӨТ
<i>Ашигт ажиллагааны шинжилгээ</i>		
19	Үйл ажиллагааны ахиуц ашиг	ҮА-ны ашиг/ЦБ
20	Ахиуц цэвэр ашиг	ТҮЦАшиг/ЦБ
21	Өөрийн хөрөнгийн өгөөж ROE	ТҮЦАшиг/ЭӨ
22	Нийт хөрөнгийн өгөөж ROA	ТҮЦАшиг/НХ
<i>Санхүүгийн тогтвортой байдал болон санхүүгийн бие даасан байдлын үзүүлэлт</i>		
23	Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	ӨТ/ЭӨ
24	Өөрийн хөрөнгөөр санхүүжилт хийх чадвар	(ЭӨ-ЭБХ)/ЭХ
25	Санхүүгийн хамаарлын коэффициент	ЭӨ/НХ
26	Санхүүжилтийн коэффициент	ЭӨ/ӨТ
27	Санхүүгийн тогтвортой байдлын коэффициент	(ЭӨ+УХӨТ)/НХ

Эх үүсвэр: Б.Бүжинлхам. 2012 он. *Санхүүгийн удирдлага*. хуудас 159-171
Ж.Пүрэвсүрэн. 2007 он. *Санхүүгийн удирдлага*. хуудас 77-83

Дээрх томъёололын дагуу салбар тус бүрийн харьцааны үзүүлэлтүүдийн дундажыг тооцохдоо боломжит утга бүхий үзүүлэлттэй компаниудыг оруулсан. Өөрөөр хэлбэл ямар нэг компаний үзүүлэлт байхгүй байсан тохиолдолд тухайн компаний үзүүлэлтийг дундаж хэмжигдэхүүн тооцоход оруулаагүй.

Уул уурхайн салбарын харьцааны шинжилгээ

Хүснэгт 2.3. Уул уурхайн салбарын санхүүгийн харьцааны дундаж үзүүлэлт

	Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	Ерөнхий дундаж
		дундаж	дундаж	дундаж	
<i>Хөрвөх чадварын шинжилгээ</i>					
1	Ажлын цэвэр капитал	-0.839945	1.155489	-0.11327	0.06
2	Эргэлтийн харьцаа	3.368424	262.4569	77.01838	114.28
3	Төлбөрийн чадварын харьцаа	1.846302	69.03698	66.60988	45.83
4	Үнэмлэхүй хөрвөх чадварын харьцаа	0.837093	65.58299	62.32628	42.91
<i>Үйл ажиллагааны шинжилгээ</i>					
5	Бараа материалын эргэлт	18	18	14	16
6	Бараа материалын дундаж наслалт	21	21	27	23
7	Авлагын эргэлт	9	59	24	30
8	Авлага цуглуулах дундаж хугацаа	40	6	15	21
9	Өглөгийн эргэлт	10	23	14	16
10	Төлбөр төлөх дундаж хугацаа	37	16	27	27
11	Үйл ажиллагааны цикл	61	27	42	43
12	Бэлэн мөнгөний цикл	24	11	15	17
13	Үндсэн хөрөнгийн эргэлт	2.119469	2.257019	1.543682	1.97
14	Нийт хөрөнгийн эргэлт	0.316874	0.766266	0.72219	0.6
<i>Өрийн шинжилгээ</i>					
15	Өрийн харьцаа	0.612205	0.517818	0.593672	0.57
16	Хүү төлөх чадварын харьцаа	-15.75349	-14.50264	190.8384	53.53
17	Өр барагдуулах өнөөгийн боломж	0.837093	65.55319	60.32264	42.24
18	Өр барагдуулах ойрын боломж	1.576972	68.72334	64.36776	44.89
<i>Ашигт ажиллагааны шинжилгээ</i>					
19	Үйл ажиллагааны ахиуц ашиг	-0.202068	-0.103177	-0.43202	-0.24
20	Ахиуц цэвэр ашиг	-0.222456	-0.163462	-0.415952	-0.27
21	Өөрийн хөрөнгийн өгөөж ROE	-0.153516	0.076696	0.056065	-0.01
22	Нийт хөрөнгийн өгөөж ROA	0.020742	-0.035654	-0.074586	-0.03
<i>Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлт</i>					
